



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/360

Есөнбулаг сум

Шүлхий өвчнөөс сэргийлэх
яаралтай дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8 дэх хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/176 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шарга сум, Хилийн цэргийн 0214 дүгээр ангийн мэдрэмтгий малд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтыг 2026 оны 06 дугаар сарын 24-ны өдрөөс эхлэн 5 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтад хамрагдах малын тоо, шаардагдах вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Яаралтай дархлаажуулалтад орон нутгийн төр захиргааны байгууллагууд, малчид мал бүхий иргэд, аж ахуйн нэгжийг татан оролцуулж, ажиллах хүч, хашаа хороо, тээврийн хэрэгсэл бусад шаардлагатай асуудлыг шуурхай шийдвэрлэж, тогтоосон хугацаанд зохион байгуулж ажиллахыг Шарга сумын Засаг дарга (Д.Батцагаан), Алтай сумын Засаг дарга (Г.Гансүх) нарт үүрэг болгосугай.

4. Шаардагдах вакцин биобэлдмэлийг татан авч хуваарилах, мэргэжил арга зүйгээр хангах, дархлаажуулалтын явцад хяналт тавих, үр дүнг тайлагнаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Р.Бүрэнбаясах)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Алтангэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны
06 дугаар сарын 28-ны өдрийн 1/28 дүгээр
захирамжийн хавсралт

ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ДАРХЛААЖУУЛАЛТАД ХАМРАГДАХ ҮХЭР, ХОНЬ, ЯМААНЫ ТОО,
ШААРДАГДАХ ВАКЦИНЫ ТУН

№	Сумын нэр	Багийн нэр	Хамруулах малын тоо, вакцины хуваарь						Нийт тун
			Үхрийн тоо	Вакцин тун	Хонины тоо	Ямааны тоо	Богийн тоо	Вакцин тун	
1	Шарга	Баянгол	933	933	3180	11242	14422	7211	8200
2	Алтай	0214-р анги	130	130	1103	2048	3151	1575	1750
ДҮН			1063	1063	4282	13290	30863	8786	9950

_ оОо _



05/04/20

$\frac{22}{\text{بقتل}}$ $\frac{50}{\text{موت (موت)}}$ $\frac{50}{\text{موت}}$

[illegible][illegible][illegible][illegible]

۵. .. یشتیسی (من ترخدا ودهیسی) د سقر سوکو یوونکیسیو . یشتیسی (یشتی) من ویر
یشتیسی . یشتیسی (من ترخدا ودهیسی) د سقر سوکو یوونکیسیو . یشتیسی (یشتی) من ویر
یشتیسی (من ترخدا ودهیسی) د سقر سوکو یوونکیسیو ..

١٢ .. من خصمك لدم ربحك عبقم هو ربحك سويكو بعكيسو لدر نرسم (مختصر) لدم بمختصر
(ب- بفس- بفس- هو مستشبه بفس بفس ..)

نَمْ ، كَسْرُوهُو

فرضه (فرضه)

8-1009105-2